Нойр хулжих өвчний шинжийн талаар сурвалж, тайлбар бүтээлүүдээс харьцуулж тодруулсан нь

Ц.Ёндон[1], С.Сээсрэгдорж[2], Qiheliga[2]

[1,2]АШУҮИС. Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[1]Өвөр Монголын Үндэстэний Их Сургууль, Монгол анагаах ухааны мэнхим
[1,2]Өвөр Монголын Үндэстэний Их Сургуулийн харьяат эмнэлгийн хороо Тунгляо 028100
Цахим шуудан: yondontsogoo3@gmail.com, Утас: +86-13154752326

Түлхүүр үг:

Монгол анагаах
Нойр хулжих
Шинж
Өвчин

Товч утга:

Үндэслэл: Нойр хулжих эмгэгийн талаар уламжлалт анагаах ухааны сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдээс харьцуулан судлах нь нойргүйдлийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, шинэ гарц гаргалгааг эрэлхийлэх онол хэрэглээний ач холбогдолтой байна. **Зорилго:** Уламжлалт анагаах ухааны сурвалж бичгүүдэд нойр хулжих эмгэгийн талаар бичигдсэнийг харьцуулан судалж ялгаатай байдлыг тодруулах. **Арга, аргачлал:** Харьцуулан жиших болон сэдвээр бүлэглэх аргуудыг ашиглан судалгааг хийлээ. **Үр дүн:** Нойр хулжих эмгэгийн талаар анх “Анагаах ухааны дөрвөн үндэс” (8-р зууны дунд үе)-ийн 16 өвчний үесийн ангиллын 35 өвчинд илрэхээр цэгцтэй дэлгэрэнгүй бичсэн нь цааш уламжлагдаж мэргэдийн бүтээлээр баяжиж давхардалгүйгээр 50 өвчний үед нойр хулжих шинж тэмдэг илрэхээр заасан нь уламжлалт анагаах ухааны онол ёсоор нойр хулжих нь биеэ даасан өвчин бус ямар нэг өвчинд давхар илэрдэг шинж болохыг тодорхой заасан нь цаад язгуур шалтгаан болж байгаа өвчнийг зөв оношилж эмчлэх нь нойргүйдлийг хам байдлаар анагаах мөн чанартай болохыг илэрхийлж байна. Түүнчлэн судалгааны эх хэрэглэгдэхүүнээс авч үзвэл нойр хулжих шинжийг тодорхой зэрэглэлд ангилж авч үзэх боломжтой байгаа төдийгүй огт нойргүй болох шинжтэй хамааралтай өвчнүүдийн ихэнх нь шарын хурц бэлгэ чанараар, нойр сэрэгших, нойр багасах шинжтэй хамааралтай өвчнүүд ямар нэгэн байдлаар хийтэй хавсарч түүний хийн хөнгөн, хөлбөрөнги бэлгэ чанараар илэрч байна. Нойр хулжих болон түүнтэй хамгийн олон давтамжтай хавсарч илэрч байгаа шинжүүд нь хийн хөнгөн, хөлбөрөнги, шарын халуун, хурц бэлгэ чанараар дийлэнх олонх нь дамжиж илэрч байгаа төдийгүй тархинд орших язгуурын амь баригч, зүрхэнд орших түгээмэл гүйгч хий, элгэнд орших өнгө урвуулагч, зүрхэнд орших бүтээгч шарын урвалттай холбоотой байна. **Дүгнэлт**: Монгол анагаах ухааны онол, эмнэлзүйн ёсоор нойр хулжих шинж илэрдэг өвчнүүдийг ялгавартай оношилж тухайн хүний нас, биеийн төрөлх өвөрмөц чанартай холбон цаг улирал, идээ ундаа, явдал мөрийн нөхцөлүүдтэй уялдуулан эмчлэхэд нойр хулжих эмгэг хам байдлаар анагаагдах боломжтой байна.

Үндэслэл: Нойр хулжих нь махбодын хямралаар эрүүл ёсоор унтаж чадахгүй болсон буюу нойрны үргэлжлэх хугацаа багасах, нойр ханахгүй байх зэрэг эмнэл зүйн хэлбэрүүдээр илэрдэг.[1] Монгол улсын СЭМҮТ-ийн 2018 оны тайланд Улаанбаатар хотын нийт хүн амыг хамруулсан судалгаагаар 2013 онд нойргүйдэл 17.1% байсан бол 2017 онд 18.7% болж өссөн болохыг тусгажээ.[2] Энэ өвчин нь АНУ-д насанд хүрэгчдийн 1/3 орчим нь нойрны эмгэгтэй байдаг ба Япон, Канад, Францад нойрны эмгэгийн тархалт 21.0%, 18.0%, 19.0% -д хүрээд байгаа аж.[3] Удаан хугацааны нойргүйдэл нь ой санамж муудах, сэтгэн бодох чадвар сулрах, бие бялдрын хүч чадал дутмаг болох, ажлын бүтээмж буурахад хүргэдэг бөгөөд цөөн тохиолдолд

хорт хавдар үүсэх хүртэл эрсдэлд хүргэдэг байна.[4,17-18]

БНХАУ-д COVID-19-ийн эхэн болон хожуу үе шатанд нойргүйдлийн тархалт 37.0% - 41.8%-д хүрч байсан нь цаг хугацааны явцад хэвээр үлдэж байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Өөрөөр хэлбэл нойргүйдэл нь олон улсад төдийгүй Монгол улсад эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болж эмчилгээч хүндрэлтэй байна. Ийм учраас нойр хулжих эмгэгийн талаар уламжлалт анагаах ухааны сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдээс харьцуулан судлах нь нойргүйдлийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, шинэ гарц гаргалгааг эрэлхийлэх онол хэрэглээний ач холбогдолтой гэж үзсэн болно[5].

Зорилго: Уламжлалт анагаах ухааны сурвалж бичгүүдэд нойр хулжих шинжийн талаар бичигдсэнийг харьцуулан судалж ялгаатай байдлыг тодруулах.

Зорилт:

1. Нойр хулжих шинж тэмдэг аль үесийн ямар өвчинд илэрч байгааг уламжлалт сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдээс харьцуулан тодруулах
2. Уламжлалт сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдээс нойргүйдэх эмгэгийн ялгаатай байдлыг тодруулах
3. Нойр хулжих шинжүүдтэй хавсарч илэрч байгаа зонхилох шинжүүдийг харьцуулан тодруулах

Арга, аргачлал: Судалгааг **х**арьцуулан жиших болон сэдвээр бүлэглэх аргыг ашиглан “Эм заслын саран хаан”, “Анагаах ухааны дөрвөн үндэс” сурвалж, “Хөх бидэр”, “Лхантав” тайлбарууд, “Дөрвөн рашаан”, “Монгол эм эмнэлгийн түүвэр”, “Монгол эмнэлгийн эрдэнийн сан” зэрэг монгол мэргэдийн эх сурвалжууд, нэг сэдэвт бүтээлүүд, эрүүл мэндийн цахим сан зэрэг эх сурвалжийн хүрээнд гүйцэтгэв.

Үр дүн: Бидний эх хэрэглэгдэхүүн болгож авсан бүтээлүүдээс нойр хулжих шинжийн талаар анх НТІ-ІІ зуунд бичигдсэн хэмээн үздэг “Эм заслын саран хаан” сурвалжид 3 зүйлийн өвчний үесийн ангилалд хамаарах 3 өвчинд илрэхээр бичигджээ. Нойр хулжих эмгэгийн талаар анх “Анагаах ухааны дөрвөн үндэс” (8-р зууны дунд үе)-т 16 өвчний үесийн ангиллын 35 өвчинд илрэхээр цэгцтэй дэлгэрэнгүй бичсэн нь цааш уламжлагджээ. “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-ийн томоохон тайлбарууд болох Дэсрид Санжаажамцын 1650 оны үед бичсэн “Хөх биндэрьяа”-д 8 зүйлийн өвчний үест хамаарах 21 өвчинд, 1705 оны үед бичсэн “Лхантав”-д 4 зүйлийн өвчний үест хамаарах 11 өвчинд, харин Ишбалжирын “Дөрвөн рашаан”-д 14 өвчний үест хамаарах 27 өвчинд нойргүйдэх шинж илрэхээр заасан нь Монгол мэргэдээс хамгийн олон өвчнийг хамруулсан болох нь харагдаж байна. Түүнчлэн Монгол мэргэдийн нэг Жамбалчойжиданзандэрэнлэй бүтээл “Эрдэнийн сан”-д 14 зүйлийн өвчний үест хамаарах 17 өвчинд нойргүйдэх шинж илрэхээр заасны дотор бахуу өвчин, ашиг өвчин гэж заасан нь орчин үеийн анагаах ухааны онолоор дотоод шүүрлийн өвчнүүдтэй дүйдэг нь онцлог ялгаатай байдаг. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Нойргүйдэх шинж илэрч буй өвчнүүд

Д/д	Сурвалжийн нэрс	Нойргүйдэх шинж илэрч буй өвчнүүд
1	Анагаах ухааны дөрвөн үндэс[8] / VIII зууны дунд үе /	А.Гурван гэмийг анагаах үесийн 1.Хийн өвчин, 2.Шарын өвчин. Б. Халуун өвчнийг анагаах үесийн 1. Ерөнхий шинжийн гадар шинжид, 2.Эс боловсорсон халуун, 3.Хоосорсон халуун, 4.Нуугдсан халуун, 5. Хямарсан халуун, 6.Хижгийн халуун өвчин 7.Бодоо өвчинд. В.Цул савын өвчний үесийн 1.Зүрхний өвчин, 2.Уушгины өвчин, 3.Элэгний өвчинд. Г.Хурмал өвчний үесийн 1.Борын өвчинд. Д.Хаван өвчний үесийн 1.Цайвар хаван өвчинд. Е.Мэдрэлийг анагаах үесийн 1.Цагаан судасны өвчинд. Ё.Хүүхдийн өвчнийг анагаах үесийн 1.Тахал өвчинд. Ж.Эмэгтэйн өвчнийг анагаах үесийн 1.Эмэгтэй өвчний умайн хорхой хөдлөх өвчинд. З. Хорын өвчнийг анагаах үесийн 1. Найруулсан хорын өвчинд. К. Хэсэг бусаг өвчнийг анагаах үесийн 1.Шар усны өвчин, 2.Ундаасах өвчин, 3.Шижин өвчин, 4.Судлын өвчнүүдийн үед нойр хулжих шинж илэрнэ гэж заажээ.
2	Эм заслын саран хаан[9] / НТІ-ІІ зуун /	Хорхойгоор умартуулагч дор халуун шинжид нойр өчүүхэн болох гэж тэмдэглэсэн байна.
3	Алтан хадмал[10] /XVII зуун /	Онолын үндэсний энэ тайлбарт шарын өвчин хямарсан өвчинд нойр хулжих шинж илэрнэ гэжээ.
4	Хөх бидэр[11] /XVII зуун /	Хямарсан халууны хатгалга өвчний үед, уушги хийгээд зүрхний хоосорсон халуунд, хий өвчний язгуурын ангиллуудад нойр хулжих шинж илэрнэ гэж тодруулжээ.
5	Лхантав[12] / XVIII зуун /	Үгдэрсэн халууны ханиад өвчний бүлэгт, охор хатгалга, шар судалд гүйсэн өвчин, толгойн өвчинд нойр хулжих шинж илэрнэ гэж нэмэлт хийжээ.
6	Дөрвөн рашаан[13] /XVIII зуун/	Монгол мэргэдийн нэг Ишбалжирын энэ бүтээлд Өөх барагдсан үед, Халуун өвчний 24 нэмэр өвчин, нялхсын адын өвчинд нойр хулжина гэж нэмэлт хийсэн байна.
7	Монгол эмнэлэгийн эрдэнийн сан[14] / XVIII зуун /	Монгол мэргэдийн нэг Миндолномунхан Жамбалчойжиданзандэрэнлэйн бүтээлд хижиг өвчин, бодо өвчин улаан нүдийг засах бүлэгт, уушгины шургасан дагшуур өвчинд, бахуу өвчнийг засах үед, шараас болсон ашиг өвчнүүдэд нойр хулжих шинж илэрнэ гэж нэмэлт хийжээ.
8	Монгол эм эмнэлэгийн түүвэр[15] /XIX зуун /	Монгол мэргэдийн нэг Чоймпэл тойны энэ бүтээлд Зүрхэнд шар оршсон үед, халуун шарын үед, хоосорсон халуунд нойр хулжих шинж илэрнэ гэжээ.

“Монгол эм эмнэлгийн түүвэр”-д 11 зүйлийн өвчний үест хамаарах 13 өвчинд тус тус нойр хулжих шинж тэмдэг илрэхээр заажээ. Нийтдээ давхардалгүйгээр 50 өвчний үед нойр хулжих шинж тэмдэг илрэхээр заасан нь уламжлалт анагаах ухааны онол, эмнэлзүйн ёсоор нойр хулжих нь биеэ даасан өвчин бус ямар нэг өвчинд давхар илэрдэг шинж болохыг тодорхой заасан нь цаад язгуур шалтгаан болж байгаа өвчнийг зөв оношилж эмчлэх нь нойргүйдлийг хам байдлаар анагаах мөн чанартай болохыг илэрхийлж байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Нойргүйдэх шинжийн ялгаатай байдал

№	Ангилал	Нойр хулжих шинж илэрч буй өвчнүүд			
		Нойр сэргэгших	Нойр бага, өчүүхэн болох	Огт нойр үгүй болох	Бусад /заримдаа нойргүйдэх/
1	Анагаах ухааны дөрвөн үндэс[8] / VIII зууны дунд үе /	Халуун өвчний ерөнхий шинж, нуугдсан, хямарсан халуун өвчин, хижгийн халуун өвчинд.	Хий өвчнийг анагаах үест, зүрхний өвчинд, шар усны өвчин, шарын өвчин. Эс боловсорсон халуун, халдварт хижгийн халуун, шижин өвчин, цагаан судасны өвчин, хүүхдийн тахал өвчин, судлын өвчинд.	Борын өвчинд. шар өвчин. хоосорсон халуун өвчин, элэгний өвчин, ундаасах өвчин, эмэгтэй өвчин, судлын өвчин.	цайвар хаван, хурмал хижгийн шарын хувь их шинжид, найруулсан хорын өвчинд,
2	Эм заслын саран хаан[9] / НТІ-ІІ зуун/	Хийн хижиг өвчин,	Зүрхний хий өвчин, хорхойгоор умартуулагч дор халуун шинж,		Ерөнхий хий өвчин,
3	Алтан хадмал[10] / XVII зуун /		Хий арвидсаны шинж, өөх барагдсан шинж,	шар хямарсанд	
4	Хөх бидэр[11] /XVII зуун /		хямарсан халууны хатгалга өвчний үед,	Уушги хийгээд зүрхний өвчин, язгуурын хий өвчний үед,	
5	Лхантав[12] / XVIII зуун /			охор хатгалга шар судалд гүйсэн өвчинд	Үгдэрсэн халуун өвчин, толгойн өвчинд
6	Дөрвөн рашаан[13] /XVIII зуун/				Халуун өвчний 24 нэмэр өвчинд
7	Монгол эмнэлэгийн эрдэнийн сан[14] / XVIII зуун /	Улаан нүдийг засах бүлэгт,	цагаан бодын өвчин, уушгины шургасан дагшуур өвчин,	хижиг өвчин, хий махбод нь хүчин төгссөн гурван хар хуйларсан нян хижиг өвчин,	бодоо өвчин, Уушгины шургасан дагшуур өвчин,
8	Монгол эм эмнэлэгийн түүвэр[15] /XIX зуун/		Зүрхэнд шар оршсон үед, Халуун шарын үед, халуун хоосорсон үед,		

Уламжлалт анагаах ухааны сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлүүдээс нойр хулжих эмгэгийг тодорхой зэрэглэлд ангилж авч үзэж боломжтой байна. Эх хэрэглэгдэхүүн болгож байгаа бүтээлүүдэд нойр хулжих шинжийг нэгэн адил зэрэглэл болгож хувааж ангилаагүй байгаач бүгд тодорхой нэгэн өвчинтэй хамааруулж үзсэн байна. Огт нойргүй болох шинжтэй хамааралтай өвчнүүдийг анхаарч үзвэл ихэнх олонх нь цулын болон ерийн халуун, хижгийн халуун, гурван хар хуйларсан хүч ихтэй халуунууд орж байгаа нь шарын хурц бэлгэ чанартай холбоотой болохыг харуулж байна. Харин нойр сэрэгших, нойр бага болох шинж бүхий өвчнүүдийн ихэнх нь ямар нэгэн байдлаар хийтэй хавсарсан байгаа нь хийн хөнгөн, хөлбөрөнги бэлгэ чанартай холбоотой байна. (Хүснэгт.2)

Нойргүйдэх шинж хавсарч илэрч байгаа гурван гэмийн анагаах үесийн хий, дотор өвчнийг анагаах үесийн бүх төрлийн хавангууд, цул, савыг анагаах үесийн өвчнүүд, хэсэг бусаг өвчний үесийн өвчнүүд, хүүхдийн тахал, цагаан судасны өвчнүүд, найруулсан хорын өвчний өөхний тамир үүсэхэд уламжлалт анагаах ухааны онол ёсоор хийн гэмүүд заавал оролцож байна. Өөрөөр хэлбэл эдгээр өвчнүүдэд хий гэм өвчний шалтгаан болж илүү нөлөөлж байгаа нь тухайн эрхтэн хий гүйх мөр, орших орон болж байгаагийн зэрэгцээ цагаан судсаар хий+шар ус, хар судсаар хий+цус гүйдэгтэй холбон авч үзэх нь илэрхий байна. Мөн эдгээр шинжүүд нь хийн нарийн бэлгэ чанараар өвчний урхаг бүх биед тархсантай холбоотойн зэрэгцээ хийн хөнгөн, хөлбөрөнги бэлгэ чанартай холбоотой шинжүүд дийлэнх олонход илэрч байна. Түүнчлэн хамгийн их давтамжтай илэрч байгаа эвшээх, солиорох мэт болох, зүрх долгисох, бие чичрэх, толгой эргэх шинжүүд нь мөн л хийн нарийн, хөнгөн, хөлбөрөнги чанартай холбоотой байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Нойргүйдлийн үед хавсарч илэрч байгаа шинжүүдийн ялгаатай байдал

Д/д	Үесийн ангилал	Нойргүйдэх өвчний үед хавсарч илрэх шинжүүд
1	Гурван гэмийг анагаах үес	Хийн өвчний ерөнхий хий өвчин, уушгины хий өвчин, өөх барагдсан шинжүүдэд хийн бэлчирт дарвал өвдөх, үе үе бага зэрэг солио ярих, эвшээн чичрэх, шөнөдөө их ханиах, яс үес өвдөх, хэрж хатгуулах, үе үе цочих, сэтгэл нь хөнгөрөх, сэтгэл түгших, зогьсох, турах, өнгө зүс буурах, нүд эрээлжлээд олон юм үзэгдэх, амьсгал амаргүй болох, үг олшрох, явахыг дурлах, асуухад ээрэх, хэл ээдрэх, өдөр унтаж чадахгүй болох зэрэг шинжүүд хавсарч илэрнэ. Шарын өвчний шар арвидаж судсанд гүйхэд, шарын хямарсанд, халуун шарын үед цээж амаргүй болох, бие эмзэглэх, сэтгэл зовуурьтай, ам хэл нь хатах, ам гашуун оргих, хүйтэн зүйлийг хүсэх, дотор алжаах, өдөртөө ухаан будангүй болж нойрмоглон тэсэж дийлэх үгүй болох, умдаасах, уур хилэн хүрэх, бие халуурах, тамир алдрах шиг болох зэрэг шинжүүд хавсарч илэрнэ.
2	Дотор өвчнийг анагаах үес	Хийн цайвар хаван, хий дийлэнх шижин өвчнүүдэд амьсгал амаргүй, чичирч хатгуулах хаван нь сэвсгэр бөгөөд ихсэх багасах нь хялбар шинжүүд хавсарч илэрнэ.
3	Халуун өвчнийг анагаах үес	Халуун өвчний ерөнхий шинжийн гадар шинжид, хийгээр боловсорч чадахгүй байгаа эс боловсорсон халуунд, халуунаар хоосорсон халуунд, судасны хоосорсон халуунд, хийн хоосорсон халуунд, халуун дийлэнх нуугдсан халууны ерөнхий шинжид, зүрхэнд халуун нуугдсан үед, халуун хүйтний завсрын цагт, хямарсан халууны нян халуун хижигт, халдварт хижгийн хайлж царцахын завсарт, хямарсан халууны хатгалгад, Хоосорсон халууны тус бүрийн хижгийн хоосон, хийн хоосон, хурмал хижгийн шарын хувь их үед, хий махбод нь хүчин төгссөн гурван хар хуйларсан нян хижигт, цагаан бодын мөндөр шиг мөхлөгийн хүчин бага үед болон зарим халдварт халуун өвчний үед өдөр шөнө аль ч үед унтаж чадахгүй, санаа их зовох, эмзэглэх, үе үе цочих, хий юм үзэх сонсох, сэтгэл нь хөнгөрөх, хөнгөмсөг аашлах, дэмий балай үглэх, сэтгэл зовуурьтай, бие хийгээд мэдрэл самуурах, толгой дүүрэх, чих шуугих, ам хазайх, үе нь чичрэх, толгой бие үес жанчигдсан мэт санагдах, хөл гар чичрэх, чихний сонор муудах, унтаж байхдаа дэмийрэх, чөмөг бэлхүүс яс үесээр нийтдээ янгинах, толгойгоор хатгуулах, чих нь шуугих, жихүүцэх зэрэг шинжүүд хавсарч байна.
4	Цул савын өвчнийг анагаах үес	Зүрхний өвчин: зүрхний хийн үед, зүрхэнд шар оршвол, зүрхэнд бор сарнивал, зүрх долгисох шинж, зүрхний шар ус, уушги хийгээд зүрхний халуун хоосорсонд, элэгний өвчний шинжүүдэд амьсгал давчдах, зүрх чичрэх, үг олшрох, явахыг дурлах, толгой эргэх, цээж амаргүй болох, солиорон чичрэх, баясахгүй болох, сэтгэл долгисох, цочих, амьсгаа охордох, дотор чичрэх, зүрх түгших, дотор нь муухайрах, шөнө хатгалга нь бага болно, уушги зүрхний орчим хөндүүрлэх, зүрх хоосорсон шиг санагдах шинжүүд хавсарч байна.
5	Хэсэг бусаг өвчний үес	Шар усны хоосонд нүд эрээлжлээд олон юм үзэгдэх, өдөртөө ухаан будангүй болно.
6	Хүүхдийн өвчнийг анагаах үес	Хүүхдийн тахал өвчин, нялхсын адын өвчнүүдэд цочин янцаглах, зогьсох, шүд уруулаа зуух, нүд нь гөлийх шинжүүд хавсарч илэрнэ.
7	Эмэгтэй өвчнийг анагаах үес	Эмэгтэй өвч, шөнө хатгалга нь бага болно, уушги зүрхний орчим хөндүүрлэх, зүрх хоосорсон шиг санагдах шинжүүд хавсарч байна.ний умайн хорхой хөдлөх шинжид мах хатангирдах шинж хавсарна.
8	Мэдрэлийн өвчнийг анагаах үес	Цагаан судасны өвчний толгойд буусан шинж болон толгойн өвчний шинжид ой санамж буурах, өдөр шөнө алиндч нойр алдах шинж илэрч байна.
9	Хорын өвчнийг анагаах үес	Найруулсан хорын өвчин махнаас өөх болоход тамирдах, ядрах шинж хавсарч байна.

Харин шарын гэм шалтгаантай өвчнүүдийн үед түүний халуун бэлгэ чанартай холбоотой шинжүүд илэрч байгаагийн зэрэгцээ нойр солигдох, огт нойргүй болох шинжүүд нь түүний хөнгөн, хурц бэлгэ чанартай хамааралтай байна. Түүнчлэн халуун өвчнийг анагаах үест орж байгаа өвчнүүдийн шалтгаан нь бага зэргийн халууныг хийгээр улээж тархаах, зүрх амин судсанд шунах, халуун өвчний сүүлд хийд урваж болох зааг үеүдтэй холбоотой хийн гэм оролцож үүссэн шинжүүд илэрч байна. Зарим нойргүйдэл нь уламжлалт анагаах ухааны нэгэн онцлог болсон адын нөхцөлөөр үүсэж байна. Хорын өвчний үеийн нойргүйдэл нь хор тунгалгийг хөлөглөн бүх бие махбодоор тархаж тунгалаг цөвийн ялгаралтаар дамжин долоон тамир дэс дараалан боловсроход оролцож хорын урхаг дөрөвдөх тамир хүрч шунасантай холбоотой илэрч байгаа буюу “Өөх барагдвал нойр багасаж турж эцэх, арьс биеийн өнгө нь хөх цайвар болно” гэдгийг харуулж байна.[16]

Хэлцэмж: Нойр хулжих эмгэгийн талаар сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлээс харьцуулан тодруулахад “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн өвчний 16 үесийн ангилалд хамаарах нийт 35 өвчинд илрэхээр заасан нь хамгийн цэгцтэй дэлгэрэнгүй бичигдсэн бөгөөд цаашид уламжлагдаж үе үеийн мэргэд баяжуулж нийт 50 өвчний үед нойр хулжих шинж тэмдэг илрэхээр заажээ. Уламжлалт анагаах ухаанд нойр хулжих шинж эдгээр 50 өвчний алинтай хамааралтай болохыг оношилж тогтоосонтой холбоотой нойргүйдлийн шалтгааны эсрэг үр дүнтэй эмчилгээ хийх боломжтой

байна.

Нөгөө талаар дээрх 50 өвчний хүрээнд хөөж тодруулахад нойр хулжих эмгэгийг тодорхой зэрэглэлд ангилж авч үзэх боломжтой байгаа төдийгүй тэдгээр нь тодорхой гэмийн тодорхой бэлгэ чанараар дамжиж илэрч байгааг таньж мэдэж болохын зэрэгцээ ялгавартай оношлох боломжтой байгаа нь эмнэлзүйн ач холбогдол ихтэй юм.

Хийн бэлгэ чанаруудаар дамжиж илэрч байгаа нойргүйдэл нь толгойд орших амь баригч хийн урвалтын "Толгой эргэх, амьсгал саадтай болох, горойх, сэтгэл тогтворгүй, зүрх гол судас дэлсэх, мэдрэхүйн эрхтний үйл ажиллагаа муудах, эвшээх, найтаах, хэхрэхэд төвөгтэй болох", зүрхэнд орших түгээмэл гүйгч хийн урвалтын "Зүрхээр өвдөх, дотор муухайрах, үг яриа олшрох, цочромтгой болох ухаан алдаж унах, дэмийрэх, айх, цочих" шинжүүдтэй илүү хавсарч байна.[16]

Харин шарын гэмийн үед зүрхэнд орших бүтээгч шарын урвалтын "Зүрхээр хатгаж өвдөх, дотор давчдах, ам цангах, бие чичрэх, уушги, зүрх халуун оргих" болон элгэнд орших өнгө урвуулагч шарын урвалтын "Ходоод дүүрэх, шээс шарлах, бие хүнд оргиж тамир доройтох, бие шарлах" шинжүүдтэй холбооттой байна.[16]

Нөгөө талаар судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож авсан бүтээлүүдэд нойр хулжих шинжийн зэрэглэл буюу ялгаатай байдалд хамаарах өвчнүүдийг нэгэн адил хувааж ангилаагүй нь тухайн хүний нас, биеийн төрөлх өвөрмөц чанартай болон цаг улирал, идээ ундаа, явдал мөрийн нөхцөлүүдтэй машид холбоотой зүй ёсны байгааг оношилгоо, эмчилгээнд анхаарах ёстойг харуулж байна.

Дүгнэлт:

1. Нойр хулжих эмгэгийн талаар сурвалж, тайлбар, мэргэдийн бүтээлээс харьцуулан тодруулахад "Анагаах ухааны дөрвөн үндэс"-ийн 16 үесийн өвчний ангилалд нийт 35 өвчинд илрэхээр анх цэгцтэй дэлгэрэнгүй бичигдсэн нь цаашид уламжлагдсаныг үе үеийн мэргэд баяжуулж нийт 50 өвчний үед нойр хулжих шинж тэмдэг илэрч байгааг оношилж анагаахад нойргүйдэл хам байдлаар эмчлэгдэх боломжтой байна.
2. Судалгааны эх хэрэглэгдэхүүнүүдээс харьцуулан тодруулахад нойр хулжих эмгэгийг тодорхой зэрэглэлд ангилж авч үзэх боломжтой байгаа төдийгүй тэдгээр нь тодорхой гэмийн тодорхой бэлгэ чанараар дамжиж илэрч байгааг таньж мэдэж болохын зэрэгцээ ялгавартай оношлох боломжтой байна.
3. Нойр хулжих эмгэгийн үед хамгийн олон давтамжтай хавсарч илэрч байгаа шинжүүд нь хийн хөнгөн, хөлбөрөнги, шарын халуун, хурц бэлгэ чанараар дийлэнх олонх нь дамжиж илэрч байгаа төдийгүй язгуурын амь баригч, түгээмэл гүйгч хий, өнгө урвуулагч, бүтээгч шарын урвалттай холбоотой байна.

Ном зүй:

1. *Цагаанхүү Г. Мэдрэл судлал [М]. Улаанбаатар хот 268, 270.*
2. *Эрүүл мэндийн хөгжилийн төв, Статистик тайлан 2017-2022он http://hdc.gov.mn*
3. *Xuehuiyuan, Xinliyali. Анагаахын оюутнуудын нойрны чанарт нийгмийн дэмжлэг үзүүлэх нөлөөллийн судалгаа[D]. Guangzhou: Nanfang Анагаах ухааны их сургууль.2018.*
4. *Chenjianbo. Архаг нойргүйдлийн эмчилгээнд мэдээ алдуулах нойрыг тэнцвэржүүлэх аргын үр дүнтэй байдал [J]. (Gu chengxian renmin yiyuan, 441700): Дэлхийн нойргүйдлийн анагаах ухааны сэтгүүл. 2021:7.(8) 1136, 1137.*
5. *Yun Li [1], Baixin Chen [2], Zhuoting Hong [2], Qimeng Sun [2], Yanyuan Dai [2], Maria Basta [3], Xiangdong Tang [4], Qingsong Qin[5] Хятад дахь COVID-19 тахлын эхэн ба хожуу үе шатанд нойргүйдлийн шинж тэмдгийг системчилсэн тойм, мета-анализ судалгаа [J]. Cnki.net.2020.04.*
6. *Дашжамц Д. Шинжлэх ухааны судалгааны ажлын онол-арга зүйн үндэс[М]. Монгол улс: 2017:40*
7. *Батсайхан Н, Сээсрэгдорж С, Монгол уламжлалт анагаах ухаан: Зарим эх сурвалжийн нягтлан шинжлэл[J]. Монгол улс: 2021:15.*
8. *Их ютог Ёндонгомбо// Төмөр Д /хөрвүүлсэн/ Лүндэн./хянасан// Анагаах ухааны дөрвөн үндэс [М]. Улаанхад: Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо 1987:9. 199, 202, 206,211,213.*
9. *Багана /эрхэлсэн найруулагч/. Эм заслын саран хаан[М]. Улаанхад: Өвөр монголын хэвлэлийн бүлгэм, Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2014:12.199,220, 223, 230, 232.*
10. *Дарма маарамба Лувсанчойдог. Алтан хадмал[М]. Хөххот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2015:04.939, 941.*
11. *Дэсрид Санжаажамц. Хөхбидэр [М]. Хөххот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2015:04.*
12. *Дэсрид Санжаажамц. Лхантав [М]. Улаанхад: Өвөр монголын хэвлэлийн бүлгэм, Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2016:6.(дунд)15,28, 280,281, 418,424, (доод)1, 50,55.*
13. *Сүмбэ хамба Ишбалжир. Дөрвөн рашаан[М]. Хөххот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2015:6. 71,72, 100, 105, 138,139,144,145,334, 337.*
14. *Жамбалчойжиданзанпэрэнлэй Монгол эмнэлгийн эрдэнийн сан [М]. Хөххот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1977.05.407,408, 444, 459, 677, 689, 730, 870.*
15. *Лувсанчоймпил. Монгол эм эмнэлгийн түүвэр [М]. Хөххот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1999:10.1,5,10, 16, 22, 420,421.*
16. *Сээсрэгдорж С, Цэрэндагва Д, Монгол анагаах ухааны өвчнийг шинжилж нотлохуйн нэгдмэл толь[М]. Улаанбаатар хот: 2023:80, 83.*
17. *Xiulan. Хий дийлэнх нойр хулжих өвчнийг монгол анагаах ухааны бүлээн зүү эмчилгээгээр засах эмнэлзүйн судалгаа [D]. Beijing: 2017.05.*
18. *Manduriwa. Монгол эмнэлгийн бүлээн зүү засал ба Сүгмэл-3-ийн тан харханд үүсгэсэн нойр хулжих эмгэг загварт үзүүлсэн уг ёсны судалгаа [D]. Beijing: 2018.05.*

Comparative Analysis and Elucidation of Insomnia across Traditional Medical Literature

Yondon Ts[1,2], Seesregdorj S[2], Qiheliga[2]

[1,2]International School of Mongolian Medicine, MNUMS
[1]Department of Mongolian medicine,Inner Mongolia Minzu University
[1,2]Affiliated Hospital of Inner Mongolia University for Nationalities, Tongliao City 028100, China
E-mail: yondontsogoo3@gmail.com, Tel: +86-13154752326

Background: This research delves into exploring traditional medical sources, and interpretations concerning insomnia, possessing both theoretical and practical significance in augmenting the variety of insomnia therapy methods and innovating therapeutic approaches.
Aim: To compare and analyze the literature on insomnia in traditional medical literature and clarify the differences.
Materials and Methods: The study was conducted using comparative and thematic grouping methods.
Results: Insomnia detailed in the symptoms of 35 diseases spanning 16 categories within the "Medical Four Foundation" from the mid-8th century. This knowledge evolved and expanded through subsequent scientific works, elucidating that insomnia symptoms manifest in 50 diseases without redundancy. Traditional medicine theory unequivocally posits that insomnia is not a disease by itself but rather a symptom of an underlying disease which indicates accurate diagnosis and treatment targeting the root cause emerge as the crux of managing insomnia effectively.
Additionally, the traditional medicine literature permits the classification of insomnia symptoms into certain degrees, most of the diseases related to insomnia are characterized by the "Shariin Khurts Belge" and chronic sleep disorder is associated with the manifestation of "Khiin Khungun, Khulburungu" symbolism.
Insomnia, along with its prevalent associated symptoms such as "Khiin Khungun", "Khulburungu" and "Shariin Khaluun and Khurts", intertwines with the "Ami barigch khii" in the brain, the "Ungu urvuulagch shar" in the liver, the "Tugeemel guigch khii" and "Buteegch shar" in the heart.
Conclusion: According to the concept of Mongolian traditional medicine, sleep disorders are diagnosed differently and treated by following age, physical characteristics, seasonal variations, dietary habits, and lifestyle.

Keywords: Mongolian traditional medicine, Insomnia, Symptoms, Diseases